**ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2024-2027 ОНЫ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

| Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Стратеги /арга зам/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2023 | Зорилтот түвшин 2025 | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| **Ерөнхий чиг үүргийн нэр: 1. Гэмтэл согогийн цогц тусламж, үйлчилгээг олон улсын удирдамж, стандартын дагуу үзүүлэх.** | | | | | | |
| Үндсэн чиг үүрэг- 1.1: Олон улсын стандарт, удирдамжийн шинэчлэгдсэн хувилбаруудыг баримталж ажиллах. | | | | | | |
| Зорилт-1. Гэмтэл согогийн цогц тусламж үйлчилгээнд олон улсын стандарт удирдамжийг нэвтрүүлэн ажиллана. | Арга хэмжээ-1. Олон улсын стандартад нийцсэн менежментийн тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ. | MNS 7101:2023 магадлан итгэмжлэлийн шалгуурын хувь | 30 | 100 | “Аму консалтинг” ХХК-тай гэрээ байгуулж тус стандартыг нэвтрүүлэх төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. | 50% |
| | Арга хэмжээ-2. Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO/IEC:27001:2013 нэвтрүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 10 | 80 | 2025-05-26 өдрийн А/84 тоот тушаалыг үндэслэж ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу тендер зарлаж Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийхээр төлөвлөж байна. Тус аудитын зөвлөмжийн дагуу үйл ажиллагааг хэргэжүүлэн ажиллана. | 75% |
| | Арга хэмжээ-3. Сувилахуйн тусламж, үйлчилгээний стандартыг мөрдөж гардан үйлдлийн чадавхжуулах сургалт зохион байгуулан үнэлгээний шалгуур | Зохион байгуулсан сургалтын тоо | 5 | 15 | Төвийн нийт сувилагч нарт долоо хоног бүр 3 удаа гардан үйлдлийн стандартын сургалтыг нийт 30 удаа буюу сард 6 удаа зохион байгуулан ажиллаж байна. | 100% |
| | | Нийт сувилагч үнэлгээний дундаж хувь | - | 70 | 2025 оны 2 дугаар сараас 2025 оны 05 дугаар сар хүртэлх хугацаанд, гадны байгууллага, сургуультай хамтарч Төв болон салбар эмнэлгийн сувилагч мэргэжилтний хөгжлийн дадлага ур | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | үзүүлэлт боловсруулж үнэлнэ. | | | | чадварыг түвшин тодорхойлох үнэлгээг амжилттай зохион байгуулсан. Онол болон гардан ур чадварын үнэлгээнд нийт 270 сувилагч хамрагдсан байна. Сувилагч мэргэжилтний хөгжил, ур чадварын өөрийн үнэлгээний түвшинд хамрагдсан сувилагч нарын дундаж үнэлгээ (73.3%) -иар үнэлэгдсэн байна. | 100% |
| Үндсэн чиг үүрэг-1.2: Орчин үеийн оношилгоо, эмчилгээний шинэ дэвшилтэд технологийг нэвтрүүлэх. | | | | | | |
| Зорилт-2.<br>Анагаах ухааны орчин үеийн дэвшилтэт технологи, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үе шаттай нэвтрүүлнэ. | Арга хэмжээ-1.<br>Эмнэлгийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ. | Орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжийн тоо | 4 | 12 | Төвийн хэмжээнд тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологийн 5 төрлийн 6 ширхэг тоног төхөөрөмжийг худалдан авсан. Үүнд:<br>MRI оншилгооны аппарад-1 ширхэг<br>ХҮчил төрөгчийн үйлдвэрийн тоног төхөөрөмж-1 ширхэг<br>Багаж бакетлагч-2 ширхэг<br>Ходоодны дуран -1 ширхэг | 50% |
| | Арга хэмжээ-2.<br>Донор эдийн санг байгуулж,үйл ажиллагааг тогтмолжуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 10 | 60 | - | 0% |
| | Арга хэмжээ-3.<br>Спортын гэмтлийн үеийн тусламж үйлчилгээг цогцоор нь үзүүлэх төвийг байгуулна. | Төв байгуулах үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 50 | 100 | Спортын гэмтлийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд 6<br>зорилтын хүрээнд 21 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 43.2 %-ийн үзүүлэлттэй байна. | 43.2% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Арга хэмжээ-4. Нөхөн сэргээх эмчилгээг цогцоор үзүүлэх нэгжийг байгуулна. | Нэгж байгуулах үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 50 | 100 | Нөхөн сэргээх эмчилгээг цогцоор үзүүлэх нэгжийн үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд 6 зорилтын хүрээнд 15 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 45.2 %-ийн үзүүлэлттэй байна. | 45.2% |
| **Ерөнхий чиг үүргийн нэр: 2. Үйлчлүүлэгч болон ажилчдад эрсдэлгүй, ээлтэй орчин бүрдүүлэх.** | | | | | | |
| Үндсэн чиг үүрэг- 2.1: Байгууллагын гадаад, дотоод эрсдэлийг үнэлэх түүнд чиглэсэн арга хэмжээ авах. | | | | | | |
| Зорилт-3. Байгууллагын гадаад, дотоод эрсдэлийг үнэлэх, түүнд чиглэсэн арга хэмжээ авна. | Арга хэмжээ-1. Эрсдэлийн үнэлгээ хийх мэргэжлийн баг байгуулж үйл ажиллагааг тогтмолжуулна. Эрсдэлийн мэдээллийн сан бүрдүүлнэ. | Орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, эрсдэлийн үнэлгээний сан бүрдүүлэлтийн хувь | 25 | 75 | Төв эмнэлгийн хэмжээнд 2025 оны хагаас жилийн байдлаар онд эмнэлзүйн болон эмнэлзүйн бус нийт 182 эрсдэл бүртгэгдсэнээс өндөр буюу улаан эрсдэл 2 буюу нийт эрсдэлийн 1.1%-г эзэлсэн байна. Төвийн хэмжээнд эрсдэлийн санг үүсгэж эрсдэлийг бууруулах төлөвлөгөө гарган ажиллаж тайланг хагас жилээр гарган дүгнэсэн. | 50% |
| | Арга хэмжээ-2. Жил бүрийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан үйл ажиллагааны төлөвлөгөө гарган эрсдэлийг бууруулж ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 25 | 75 | Бүртгэгдсэн эрсдэлийг боломжид чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөөг гаргаж хэрэгжилтийг тогтмол үнэлж, үр дүнг тооцож ажиллаж байна. 2025 оны эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар 78.2% үзүүлэлттэй. | 78,2% |
| | Арга хэмжээ-3. Төвийн гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, багийг чадавхжуулан бэлэн | Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 20 | 60 | ОБЕГ-аас 03 дугаар сарын 27-ны өдөр улсын хэмжээнд зохион байгуулсан гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтад Гэмтэл согог судлалын үндэсний төв болон салбар эмнэлгийн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байдлын төлөвлөгөөг боловсронгуй болгоно. | | | | эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, албан хаагчид идэвхтэй хамрагдлаа. Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвөөс улс орон даяар зарлан мэдээллийн дохиог гурван удаа дамжуулсан бөгөөд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, хэвтэн эмчлүүлэгчид өөрт ойр байгаа аюулгүйн цугларах талбайд гарч, дадлага сургуулилтад оролцсон юм. | 50% |
| | Арга хэмжээ-4. Үндэсний осол гэмтлийн үеийн яаралтай тусламжийн багийг байгуулж тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ. | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 10 | 70 | Төвийн 2025 оны худалдан авах төлөвлөгөөнд эмнэлгийн бус тоног төхөөрөмж худалдан авхаар тусгаж төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,ажил, үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус худалдан авалтаар нийт 3 багц 175 ш яаралтай тусламж үзүүлэх багийн шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгсэлийг авч бэлэн байдлын хангалтийг нэмэгдүүлэн ажиллаа. | 70% |
| | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 10 | 70 | - | 0% |
| Үндсэн чиг үүрэг-2.2: Барилга байгууламж, эмнэлгийн тоног төхөөрөмж, техник, хэрэгслийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар холбогдох стандартын шаардлагыг хангаж ажиллах. | | | | | | |
| Зорилт-4. Барилга байгууламжийн хүрэлцээг нэмэгдүүлж, | Арга хэмжээ-1. Шинээр нэвтрүүлж буй тоног төхөөрөмжүүдийн аюулгүй ажиллагааны | Сургалтын тоо | 3 | 9 | Тоног төхөөрөмжүүдийн аюулгүй ажиллагааны заавар, ашиглалтын ажлын байран дахь сургалтыг 5 удаа зохион байгуулсан. | 60% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| эмнэлгийн тоног төхөөрөмж, техник, хэрэгслийн аюулгүй ажиллагааны стандартыг баримталж ажиллана. | заавар, ажлын байран дахь сургалт явуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна. | Сургалтад хамрагдсан ажилтны хувь | 3 | 50 | Тоног төхөөрөмжүүдийн аюулгүй ажиллагааны заавар, ашиглалтын ажлын байран дахь сургалтад 125 эмч эмнэлгийн мэргэжилтэн буюу нийт ажилчдын 2% нь хамрагдсан байна. | 2% |
| | Арга хэмжээ-2. Өргөтгөлийн барилга барих, өргөтгөлийн барилга барих төсвийг шийдүүлнэ. | Барилга угсралтын ажлын хувь | 10 | 60 | Саналыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх саналаар хүргүүлсэн. 2025 оны улсын төсөв суугдаагүй. | 0% |
| | Арга хэмжээ-3. Сургалтын орчин нөхцөлийг нэмэгдүүлж сайжруулна. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 70 | Эмнэлэгт суурилсан төгсөлтийн дараах сургалтыг чанаржуулах үүднээс ГССҮТөвийн Салбар эмнэлгийн амбулаторийн 3 давхарт 46м2 эмнэлзүйн ур чадварын сургалтын өрөөг шинээр тохижуулан ашиглалтад оруулсан. | 100 |
| Үндсэн чиг үүргийн нэр:2.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын эрсдэлийг бууруулах, эрт илрүүлэх, урьдчилан сэргийлж ажиллах | | | | | | |
| Зорилт-5<br>Шинэ болон сэргэж буй халдварт өвчин болон эмнэлгийн халдварын эрсдэлийг бууруулаж, урьдчилан сэргийлж ажиллана. | Арга хэмжээ-1. Төвлөрсөн ариутгалын тасгийн тоног төхөөрөмж, хүчин чадлыг нэмэгдүүлж,чанартай тусламж үйлчилгээг үзүүлнэ. | Шинэчлэн сайжруулсан ариутгал халдваргүйтгэлийн тоног төхөөрөмжийн тоо /өссөн дүнгээр/ | 2 | 8 | Төвийн мэс засал, мэдээгүйжүүлгийн нэгдсэн тасагт богино хугацаанд ариутгах ариутгалын жижиг зөөврийн автоклав 1 ширхэгийг шинээр суурилуулж ашиглаж байна. | 50% |
| | Арга хэмжээ-2. Гепатит В вирусийн дархлаажуулах шаардлагатай ажилчдыг | Гепатит В вирусийн дархлаажуулалтад хамрагдах шаардлагатай | 70 | - | Гепатит В вирусийн эсрэг дархлаажуулалтын I дугаар тун **4**, II дүгээр тунд **2**, III тунд **23**, booster **2**, эмч ажилчдыг хамруулсан байна.<br>- III-р тунд бүрэн хамрагдсан хүмүүсийг Гепатит В вирусийн эсрэг дархлал тогтцын | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | дархлаажуулалтанд хамруулсан байна. | ажилчдын хамрагдсан хувь | | | шинжилгээнд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>- Улаан бурхан өвчний эсрэг дархлаажуулалтад 100<br>- Галзуу өвчний- **1558**,<br>эсрэг дархлаажуулалтад үйлчлүүлэгчийг хамруулан ажилласан байна. | |
| | Арга хэмжээ-3.<br>Тархвар зүйн заалтаар дархлаажуулалтад хамрагдах ажилчдын судалгааг гарган, тогтмол хамруулна. | Дархлаажуулалтад хамрагдсан ажилчдын тоо /өссөн дүнгээр/ | 202 | 800 | 3,4 улиралд хэрэгжүүлхээр төлөвлөж байна. | 0% |
| | Арга хэмжээ-4.<br>Шинэ болон сэргэж буй халдварт өвчин, ЭТҮХХ-ын мэдээ, мэдээлэлтэй тогтмол танилцаж, тандалт судалгааг хийсэн байна. | Шинэ болон сэргэж буй халдварт өвчний илрүүлэг ЭТҮХХ-ийн тандалт хийсэн тоо | 60 | 100 | ХСХ-ын дэглэмд улирал тутамд хяналт хийж, алдаа, зөрчлийг арилгуулан ажиллаж байна. Төвийн **185**, салбар **215** сэрэмжлэх нянгийн халдвар илэрсэн эмчлүүлэгчдийн тандалтын хуудсанд тандалт хийхэд нийт тохиолдлын **82,5%** нь гадаад шалтгаант халдвар **8%** нь эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой дотоод халдвар **9,5%** нь шалтгаан тодорхойгүй халдвар байна. | 50% |
| | Арга хэмжээ-5.<br>Эмнэлгийн орчны халдварын тархах нөхцөлийг бууруулж барилгын агааржуулалтыг сайжруулах арга хэмжээ авсан байна. | Барилга байгууламжийн агааржуулалтын шинэчлэлтийн хувь | - | 40 | Эмнэлгийн орчны халдварын тархах нөхцөлийг бууруулж барилгын агааржуулалтыг сайжруулах үүднээс төвийн хэмжээнд төлөвлөгөөт хагалгааны хэсэг болон ажилчидийн өрөө тасалгаанд хана, таазны нийт 7 ширхэг эйр кондейшнийг суурилуулсан байна. | 40% |
| **Ерөнхий чиг үүрэг-3: Хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах.** | | | | | | |

| Үндсэн чиг үүрэг-3.1: Хүний нөөцийн харилцаа хандлага, мэдлэг мэргэжлийн ур чадварыг тасралтгүй сайжруулах, чадавхыг хөгжүүлэх | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Зорилт-6.<br>Хүний нөөцийн хөгжлийн бодлогыг тодорхойлж, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. | Арга хэмжээ-1.Хүний нөөцийн хөгжлийн бодлогыг тодорхойлж,ур чадварыг сайжруулна. | Эмнэлгийн менежментийн талаар чадавхжуулах сургалтад хамрагдсан удирдах албан тушаалтан эмч, эмнэлгийн ажилчдын тоо | 120 | 180 | 4 дүгээр улиралд хэрэгжүүлхээр төлөвлөсөн байна. | 0% |
| | Арга хэмжээ-2.<br>Эмч,эмнэлгийн ажилтны тасралтгүй хөгжлийг дэмжиж гадаад сургалтад хамруулна. | Сургалтад хамрагдсан ажилтны тоо | 20 | 60 | 2025 оны эхний хагас жилийн байдлаар Гэмтэл согог судлалын үндэсний төвийн нийт 21 эмч, эмнэлгийн мэргэжилтэн 8 улсын гадаадын богино, дунд болон урт хугацааны сургалт, олон улсын хурал, зөвлөгөөнд хамрагдсан байна.<br>Сургалт, хуралд оролцсон улсын тоо: 8<br>Нийт хамрагдсан ажилтны тоо тоо: 21 (эмч, эмнэлгийн мэргэжилтэн)<br>✓ БНСУ 11 эмч дунд хугацааны (1 сар) сургалт<br>✓ БНСВУ 2 эмч (дунд хугацааны сургалт)<br>✓ ХБНГУ 1 эмч<br>✓ (дунд хугацааны сургалт)<br>✓ Тайвань 1 эмч<br>✓ (урт хугацааны сургалт)<br>✓ Япон 3 эмч<br>✓ (богино хугацааны сургалт)<br>✓ БНТурк 1 эмч<br>✓ (dогино хугацааны сургалт) | 40% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ✓ БНХАУ 2 эмч<br>✓ (богино хугацааны сургалт)<br>Эдгээр сургалтууд нь байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, олон улсын шинэ техник, арга зүйтэй танилцах, туршлага солилцох, цаашлаад байгууллагын тогтвортой хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болж байна. | |
| | Арга хэмжээ-3 .ЭМЯ-ны ёс зүйн хорооны төлөвлөгөө болон ГССҮТ-ийн ёс зүйн салбар хорооны төлөвлөгөөний дагуу сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна. | Зохион байгуулсан харилцаа хандлага, ёс зүйн сургалтын тоо | 6 | 14 | Төвийн нийт ажилчдад харилцаа хандлага, үйлчилгээний соёлыг сайжруулах үүднээс удирдлагын манлайлал, хувь хүний хөгжил, байгууллагын соёл, ёс зүйтэй харилцаа зэрэг нийт 17 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 1084 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. | 100% |
| | Арга хэмжээ-4. Эмч,ажилчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 70 | Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг захирлаар батлуулан хэрэгжилтийг 100% хanган ажилласан. | |
| **Ерөнхий чиг үүрэг-4: Сургалт судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, инновацыг хөгжүүлэх, нэвтрүүлэх, бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангах;** | | | | | | |
| Үндсэн чиг үүрэг-4.1: Инновац, сайн туршлагыг нэвтрүүлэх | | | | | | |
| Зорилт-7. Нотолгоонд суурилсан анагаах ухааны хөгжил, эрдэм шинжилгээний ажил, | Арга хэмжээ-1. Шинэ бүтээл, оновчтой санаа гаргаж, батлуулна. | Эмчилгээ, оношилгоонд нэвтрүүлсэн шинэ арга технологийн тоо | 2 | 6 | Монголд анх удаа дунд чөмөгний булууны дутуу хөгжлийг дурангийн мэс заслын аргаар эмчлэх болон Ясны дутмагшилыг нөхөж гарын үйл ажиллагааг сэргээж өвчтөний амьдарлын чанарыг сайжруулж | 35% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | | | | | чөмөгт ясны дутмагшилыг нөхөх 2 нотолгоонд суурилсан мэс заслын, эмчилгээний шинэ дэвшилтэд технологийг нэвтрүүллээ. | |
| | Арга хэмжээ-2. Монголд эмчлэгдэх боломжгүй өвчний жагсаалтад орсон өвчнийг эмчилнэ. | Шинээр нэвтрүүлсэн эмчилгээний тоо | 2 | 4 | 4 дүгээр улиралд хэрэгжүүлхээр төлөвлөж байна. | 0% |
| | Арга хэмжээ-3. Орон нутагт осол гэмтлийн яаралтай тусламж үйлчилгээний чадамжийг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлнэ. | Төсөл хэрэгжүүлсэн аймгийн тоо | 1 | 5 | Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлгийн гэмтэл согогийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, төвлөрлийг сааруулах хүрээнд төслийн хүрээнд хагас жилийн байдлаар 52 оншийн хамааралт бүлгээр 413 үйлчилүүлэгчид эмийн болон мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. | 20% |
| | Арга хэмжээ-4. Шинээр нэвтрүүлсэн эмчилгээ оношилгооны талаарх судалгаа,шинжилгээ мэдээ мэдээллийг баримтжуулан мэдээллийн сан үүсгэнэ. | Сангийн бүрдүүлэлтийн хувь | - | 70 | Гэмтэл согогийн тусламж үйлчилгээний инновац, хөгжлийн чиг хандлагыг сайжруулах, мэс заслын болон мэс заслын бус эмчилгээ үйлчилгээний мэдээллийн санг үүсгэх,шинээр нэвтрүүлэх мэс заслын төсөл хөтөлбөр боловсруулах чиглэлийн дагуу Төвийн захирлын А/122 тоот тушаалаар Инновацын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг баталсан. | 0% |
| Үндсэн чиг үүрэг-4.2: Сургалтын орчинг сайжруулах | | | | | | |
| Зорилт-8. Эмнэлэгт суурилсан төгсөлтийн дараах | Арга хэмжээ-1. Эмнэлэгт суурилсан төгсөлтийн дараах сургалтыг чанаржуулж | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 60 | Салбар эмнэлэгт Эмнэл зүйн сургалтын өрөөг эм, эмнэлгийн хэрэгсэл болон нарийн загварчилж дүрсэлсэн, биет загваруудын муляж буюу анатомийн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| сургалтыг төгөлдөржүүлнэ. | зохиомол сургалтын төвийг байгуулна. | | | | модель, тусламж үйлчилгээний дууриамал орчин, цахим технологи зэргээр иж бүрэн тохижуулж, сургалтад нийцсэн тохитой орчныг бүрдүүлж өгсөн байна.<br>Энэхүү өрөө нээгдсэнээр сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтний мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, шинээр ажилд орсон мэргэжилтнүүдэд дадлагажих орчин болох төдийгүй сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах боломжыг бүрдүүлсэн байна. | 50% |
| | Арга хэмжээ-2. Төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтын тоог нэмэгдүүлнэ. | Үндсэн мэргэжлээр сургалт явуулж байгаа төрлийн тоо | 1 | 3 | “Гэмтлийн яаралтай тусламж” сургалтын хөтөлбөрийг боловсруулж байна. | 0% |
| | Арга хэмжээ-3. Эмнэлэгт суурилсан сургалтыг чанаржуулж, хүний нөөцийг чадавхжуулна. | Зохион байгуулсан сургалтын тоо | 3 | 10 | Гэмтэл согог судлалын үндэсний төв нь гадна өдөр хөгжилтэй орны эрүүл мэндийн байгууллагаас 2 зочин профессорыг урьж 2 сарын хугацаатай эрчимт эмчилгээний тасаг болон халдвар сэргийлэлт хяналтын албанд ажлын байран дахь сургалтыг зохион байгуулж эмч эмнэлгийн ажилтны мэдлэг чадварыг дээшлүүлж чадавхжуулж ажиллаа. | 20% |
| **Ерөнхий чиг үүрэг-5: Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах;** | | | | | | |
| Үндсэн чиг үүрэг-5.1: Эмнэлгийн үр ашгийг дээшлүүлж, менежментийг сайжруулах. | | | | | | |
| Зорилт-9. Эмнэлгийн үр ашгийг дээшлүүлж, | Арга хэмжээ-1.Бүтээмжид суурилсан урамшууллын | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 10 | 100 | Бүтээмж болон “Ажилтнуудын ажлын үр дүнг үнэлж мөнгөн урамшуулал олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах | 30% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| менежментийг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулна. . | тогтолцоог бий болгож хэрэгжүүлнэ. | | | | ажлын хэсгийг Төвийн захирлын А/121 тоот тушаалаар батласан. | |
| | Арга хэмжээ-2.Эмнэлгийн маркетинг, менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 40 | 4 дүгээр улиралд багтаан батлуулхаар төлөвлөгөөг боловсруулж байна. | 0% |
| | Арга хэмжээ-3. Гадаад, дотоодын байгууллагуудтай харилцан хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | Хамтын ажиллагааны гэрээ хийгдсэн олон улсын байгууллагуудын тоо | 3 | 10 | Эхний хагас жилийн байдлаар гадаад хамтын ажиллагааны хүрээнд дараах 3 эмнэлэгтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаа. Үүнд:<br>-Тайваний цэргийн нэгдсэн гуравдугаар эмнэлэг<br>-Энэтхэгийн Индомеди, эмнэлэг<br>-Турк улсын NPIstanbul Brain Hospital<br>Дотоод хамтын ажиллагааны хүрээнд АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэгтэй гэрээ байгуулан тусламж үйлчилгээг өргөжүүлэн ажиллаж байна. | 40% |
| | Арга хэмжээ-4.Төлбөртэй тусламж үйлчилгээний журмын дагуу тусламж үйлчилгээг өргөжүүлж хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Нэмэгдүүлсэн тусламж үйлчилгээний тоо /өссөн дүнгээр/ | 2 | 6 | Одоогоор мөрдөгдөж буй төлбөртэй тусламж үйлчилгээний тушаалыг мөрдөн ажиллаж байна. | 0% |
| | Арга хэмжээ-5.ЭМД-ын сангаас санхүүжүүлэх тусламж үйлчилгээний оношийн бүлгийн | Тусламж үйлчилгээ үзүүлж байгаа оношийн хамааралтай бүлгийн тоо | 156 | 165 | 2025 оны 2 сарын 14-нд тогтоолд орхигдсон болон хамтын төлбөртэй холбоотой 20 хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний өртөг зардлыг тооцож ЭМДҮЗ-ийн 04-р тогтоолын оношны | 0% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хамааралтай тоог нэмэгдүүлнэ. | | | | хамааралтай бүлгийн жагсаалтад нэмж оруулах саналыг ЭМДЕГ-т хүргүүлэн ажиллаа. | |
| | Арга хэмжээ-6.Үндсэн болон төсөвт хөрөнгийн төлөвлөлт, ашиглалт, зарцуулалтыг сайжруулан, бүртгэл мэдээллийн цахим санг байгуулна. | Үндсэн хөрөнгийн цахим бүртгэлийн программыг хөгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 60 | Санхүүгийн тооцоолохын Acolous программын шинэчилсэн хувилбарыг судалж, 7 сарын 1-нээс туршилтын журмаар хэрэгжүүлж эхэлнэ. | 0% |
| | Арга хэмжээ-7. Үндсэн болон төсөвт хөрөнгийн төлөвлөлт, ашиглалт, зарцуулалтад хөндлөнгийн хяналт тогтмол хийлгэсэн байна. | Хяналт үнэлгээ хийлгэсэн тоо /өссөн дүнгээр/ | 1 | 5 | Төрийн өмчийн бүртгэлийн программын бүртгэлд төвийн үндсэн хөрөнгийн өөрчлөлтийг бүртгэн ТӨБЗГ-т илгээж, баталгаажуулсан. Эхний хагас жилийн хөрөнгийн тооллого явуулах тушаал гарч, тооллогын бэлтгэл ажил явагдаж байна. | 0% |
| **Ерөнхий чиг үүрэг-6: Нийгмийн эрүүл мэндийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг сайжруулах, осол гэмтлийн үеийн тандалт судалгааг өргөжүүлэх** | | | | | | |
| Үндсэн чиг үүрэг-6.1: Осол гэмтлийн тандалтын тогтолцоог бэхжүүлэх, мэдээллийн санг хөгжүүлэх. | | | | | | |
| Зорилт-10. Осол гэмтлийн тандалтын тогтолцоог бэхжүүлж, мэдээллийн санг цахимжуулна. | Арга хэмжээ-1. Осол гэмтлийн цахим санг бүрдүүлэгч программуудын хөгжүүлэлт, мэдээллийн сан боловсруулах үйл ажиллагаанд санал оруулж ажиллана. | Цахим санг хөгжүүлэх оролцсон саналын тоо | 4 | 12 | Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас АМ-33 маягтыг E-health цахим 'программд шууд бүртгэх боломжтой болгосон ба программаас хэвлэн архивлаж байгаа. Эрүүл мэндийн салбарын H-info программ руу хөрвөж, халдварт бус өвчлөлийн тайлан гаргах ажлыг шийдүүлэхээр ЭМХТөвд хүсэлт албан бичгээр илгээсэн. | 100% |
| Үндсэн чиг үүргийн нэр: 6.2. Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг нэмэгдүүлж, үр дүнг сайжруулах | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Зорилт-11. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлж, осол гэмтлээс сэргийлэх эрүүл мэндийн боловсролыг сайжруулна. | Арга хэмжээ-1.Осол гэмтэл, хүчирхийллийн тандалтын мэдээллийн сангаас нотолгоонд суурилсан мэдээллийг хүн амд болон бодлого боловсруулагчдад хүргэнэ. | Осол гэмтэл, хүчирхийллийн тандалтын мэдээллийн тоо | 20 | 60 | 2025 оны эхний 5 сарын байдлаар 90 гаруй статистик мэдээлэл, судалгаа гаргасан<br>Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээ мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.<br>ЭМСайдын төвлөрлийг бууруулах төслийн хүрээнд 21 аймгийн осол гэмтлийн мэдээллийг нэгтгэн, танилцуулга хэлбэрээр боловсруулж хүргүүллээ. | 40% |
| | Арга хэмжээ-2. Холбогдох салбарууд болон 21 аймаг, 9 дүүргийн байгууллагуудад осол гэмтэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр сургалт зохион байгуулна. | Зохион байгуулсан сургалтын тоо | 4 | 16 | Тайлант хугацаанд осол гэмтэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах дараах чиглэлээр нийслэл орон нутгийн ерөнхий боловсролын сургууль цэцэрлэг, төрийн захиргааны байгуулага 6 болон "Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэгт 2 өдрийн гэмтэл согогийн тусламж үйлчилгээний төвлөрлийг саарулах төсөл боловсруулах Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах нь", "Осол гэмтлээс сэргийлэх үйл ажиллагаанд салбар дундын хамтын ажиллагаа", "Хүүхдийг ахуйн орчны осол гэмтлээс урьдчилан сэргийлье" хүүхдэд аюулгүй ээлтэй орчин бүрдүүлэх зэрэг сэдвээр 15 удаагийн сургалтыг зохион байгуулан ажилласан. | 90% |
| | Арга хэмжээ-3. Сургуулийн өмнөх наснаас нь эхлэн зөв | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | 10 | 70 | ГССҮТ-ийн Ерөнхий захирлын 2025 оны 04.07-ны өдрийн А/72 тоот тушаалын дагуу | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | дадал, зан үйл хэвшүүлэх, эрүүл мэндийн цогц боловсролын төлөвлөгөө гаргаж практик орчинд онол дадлагатай хослуулан бий болгоно. | | | | "Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн сурагчдад осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, зөв дадал хэвшүүлэх практик сургалт" ийг 2025.04.15-05.01 хүртэл НЕБ-ын 13-р сургууль болон Монгени сургуулийн дунд ангийн 250 сурагчдад осол гэмтлийн шалтгаант өвчлөлд хүргэж буй эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, ээлтэй аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр мэдээлэл сургалт онолын мэдлэг болон осол гэмтлийн үеийн анхны тусламжийн практик сургалтыг зохион байгууллаа.<br>Үүнд:<br>- Осол гэмтлээс сэргийлэх, Нийгмийн эрүүл мэндийн мэдлэг, ойлголт<br>- Чиг хэрхэн хийх вэ?<br>- Хахсан үед хэрхэн анхны тусламж үзүүлэх вэ?<br>- Амилуулах суурь тусламжийг хэрхэн үзүүлэх вэ?<br>- Боолтыг гар доорх материалаар хэрхэн хийх вэ? зэрэг сэдвээр практик сургалтыг зохион байгууллаа | 50% |

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2024-2027 оны хөгжлийн стратеги төлөвлөгөөнд 6 ерөнхий чиг үүргийн хүрээнд, 11 зорилтыг дэвшүүлж , 41 арга хэмжээ төлөвлөснөөс 2025 оны эхний хагас жилийн байдлаар:

- Хангалттай -5 арга хэмжээ
- Хэрэгжиж байгаа - 13 арга хэмжээ

- Хэрэгжилт муу-11 арга хэмжээ
- Хэрэгжээгүй -12 арга хэмжээ байна

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал: ............................. / Б.Батзориг / .........................
(албан тушаал) (гарын үсэг) (огноо)

ТАЙЛАГНАСАН:

ЭЗТМАлбаны дарга:............................./ Э.Сайнбилэг / .......................
(албан тушаал) (гарын үсэг) (огноо)